

## ЗАЯАНЫ ХАНЬ

Хаалгаар арай ядан тэмтчин орох залуу бүсгүйг автобусны зорчигчид их л өрөвдөнгүй харцгаана. Түүнийг Сузан гэх бөгөөд эмч нар буруу онош тавьж эмчилсэнээс гуч гаруйхан насандаа хараагүй болж, нэг л мэдэхэд уур уцаар, бухимдлын ертөнцөд унасан юм.



Хөөрхий бүсгүйд энэ ертөнцөд харах мэлмий, түших тулгуур болж үлдсэн цорын ганц хүн нь Марк байлаа. Тэрээр агаарын цэргийн армид алба хаана. Сузаныг хараагүй болоход түүний сэтгэл нь ихэд гутарсан боловч эхнэрээ өөртөө итгэлтэй, биеэ даасан эмэгтэй болоход нь туслах ёстой хэмээн Марк эрс шийджээ.

Сузан шинэ амьдралдаа өдөр ирэх тусам аажим аажмаар дасаж байв. Орон гэртээ байгаа айлын эзэгтэй хойно ойр зуурын ажлыг хөнгөхөн хийчихдэг боллоо. Тэр нэг үеэ бодвол хараагүй байна гэдэг тийм ч хэцүү зүйл биш болохыг ухаарч эхэлжээ. Цаг хугацаа өнгөрөх тусам тэд бие биенээ улам хайрлан, халамжилж, аливаа зүйлийг хамтарч хийдэг байв. Өдөр хоног ээлжлэн өнгөрсөөр Сузаны ажилдаа орох цаг нэгэнт болжээ. Эрүүл саруул байх үедээ ажил гэрийнхээ хооронд хол ч гэсэн автобусаар явж болоод л байдаг байсан. Харин одоо хараагүй болсон бүсгүйд ажил руугаа явна гэдэг хар дарсан зүүд мэт санагдана. Иймээс Марк өглөө бүр эхнэрээ ажил руу нь таксигаар хүргэж өгдөг боллоо. Сузан нөхөртэйгээ үргэлж хамт очиж, ирдэг болохоор сэтгэл нь тайван байдаг байв. Харин ингэж их анзаарч, асарч халамжлах нь ямар ч үр дүнгүй бөгөөд өөрөөс нь дэндүү их хараат болж байгаад Маркийн сэтгэл ихэд зовних болжээ.

Тиймээс орой Марк эхнэртээ өөрийн бодлоо хэлэхэд, Сузан ихэд цочирдон, “Чи намайг мэдэж байна уу? Би чинь сохор хүн шүү дээ. Хаашаа явж байгаагаа яаж мэдэх юм бэ? Удахгүй чи намайг орхиод явахад, би гэдэг хүн хэрхэн амьдрана даа” хэмээн бухимдан уйлав.

Эхнэрийгээ ингэж хэлэхэд, Марк их өрөвдсөн боловч “Би чамайг ажилдаа өөрөө явж чаддаг болтол чинь автобусаар хамт явах болно” гэж хэллээ. Ингээд хоёр долоо хоногийн турш Марк цэргийн дүрэмт хувцсаа өмсөн, эхнэртэйгээ хамт ажилд нь очиж, ирж байхдаа хараанаас бусад мэдрэхүйгээ ашиглан, орчин тойрныхоо баримжааг яаж олох талаар мэддэг бүхнээ зааж сургав. Мөн ажилд нь хүргэж өгдөг автобусны жолоочтой танилцуулж, өглөө бүр нэг суудал хадгалж байхыг захижээ. Хэрвээ хүн өөрөө л хичээж зүтгэвэл, ямар ч бэрхшээлийг даван туулж чаддаг жамтай. Ингээд нэгэн өглөө Сузан эртлэн босож, ажилдаа ганцаараа

явлаа. Анхны өдөр түүнд юм бүхэн хэцүү байсан ч өдрөөс өдөрт сайжирсаар, алхаа гишгээ нь хүртэл хөнгөн шингэн болж, бүхнийг хийж чаддаг болсон юм.

Нэг өглөө Сузан ажилдаа очихоор автобусанд суухад, жолооч түүнд хандан: “Бүсгүй та их азтай хүн юм” гэж хэлэв. “Хараагүй хүн яагаад азтай байдаг билээ?” хэмээн асуухад, “Өдөр бүр таныг автобусаар явахад цэргийн дүрэмт хувцастай нэг сайхан залуу байнга дагаж ирээд, гудамжаар ажилдаа хүрэх хүртэл чинь алсаас харж, ажил руугаа ормогц, гараараа үнсэлт илгээчихээд л яваад өгдөг юм даа” гэлээ.

Ингэж хэлэхэд, Сузаны нүднээс баярын нулимс мэлмэрч эхэллээ. Тэрээр нөхрийгөө ямар их ухаалаг, тэвчээртэй, өөрт нь дэндүү их хайртай, халамжтай, үнэнч хань болохыг энэ үед ухаарчээ. Зовох цагт нөхрийн чанар танигдана гэдэг энэ буюу. Бүсгүй их азтай хүн юм. Бурхан түүнд харах нүднээс илүү сэтгэлийн нүд, ханийн тэнгэр заяаж дээ.

## **БАГШ, ХУЛГАЙЧ ХОЁР**

Нэгэн үдэш Шичири Кочун багш судараа дэлгэн уншиж байтал гэрт нь хурц сэлэм агссан хулгайч дайран орж ирээд “Мөнгөө өг эсвэл амиа алдана гэж мэдээрэй” хэмээн шаарджээ. Шичири багш огтхон ч эмээлгүйгээр “Надад бүү саад бол. Тэр шүүгээнд буй. Өөрөө очоод ав” гэж хэлээд судараа цааш нь үргэлжлүүлэн уншлаа. Энэ үйлдэлд нь хулгайч гайхаж эргэлзсэн хэдий ч мөнгийг авахаар очлоо. Түүнийг мөнгийг нь авч байх хооронд Шичири багш “Бүгдийг нь битгий ав. Надад маргааш татвараа төлөх мөнгө үлдээгээрэй” хэмээн хэллээ. Хулгайч жаахан мөнгө үлдээгээд явахаар зэхэж байтал өнөөх багш гэнэт чангаар “Чи миний мөнгийг авсан хэрнээ надад талархахгүй хэрэг үү?! Энэ чинь эелдэг санагдахгүй байна шүү” гэж хэлэхэд хулгайч талархал илэрхийлээд гарч оджээ. Өнөөх хулгайч найз нартаа өөрт тохиолдсон зүйлийг яриад амьдралдаа хэзээ ч ингэж айж байсангүй хэмээн хэлжээ. Хэд хоногийн дараа өнөөх хулгайч найз нарынхаа хамтаар баригдаж Шичири багшийн гэрээс хийсэн хулгай нь илчлэгджээ. Шичири багшийг гэрчээр дуудсанд тэр ирээд “Энэ хүн надаас ямар ч юм хулгай хийгээгүй. Би түүнд тэр мөнгийг өгсөн юм. Үүний хариуд тэр ч надад талархал илэрхийлсэн билээ” гэжээ.

Энэ үйлдэл нь өнөөх хулгайчид чин сэтгэлээс гэмшил төрүүлж, суллагдасны дараа Шичири багшид шавь орж хожим гэгээрсэн гэдэг

## **АМЬДРАЛЫН ҮНЭ ЦЭНЭ**

Тэр хоёр гэрлээд 9 жил болсон байв гэсэн хэдий ч одоо хүртэл хүүхэдтэй болоогүй ажээ. Тэд 10 дахь жилдээ хүүхэдтэй болно гэж ихэд найдацгааж байв. Нөхөр нь үүнээс болж их гутардаг байжээ. Найзууд нь, ойрын хүмүүс нь тэднийг салахыг ч зөвлөдөг байв. Гэсэн хэдий ч тэд бие биедээ маш их хайртай байжээ.

Нэгэн өдөр нөхөр нь ажлаасаа ирж явтал эхнэрээ нэгэн залуутай явж байхыг харав. Залуу эхнэрийнх нь мөрөн дээгүүр тэврээд тэр хоёр маш аз жаргалтай харагджээ. Нөхөр нь үүнд ихэд цочирдсон боловч яагаад ч юм өөрийгөө буруутган, мөн дүгнэлт хийх арай болоогүй гэж бодов.

Маргааш нь нөхөр нь дахин ажлаа тараад явж байтал нэгэн кафед эхнэр нь нөгөө залуутай байхыг дахин харжээ. Энэ удаад залуу бүр түүний хацар дээр нь үнсээд босов. Нөхөр нь үүнийг хараад түрүүлж гэртээ очиж, эхнэрээ ирэхийг хүлээв. Тэр бүх зүйлийг ярьж эхнэрээсээ сална гэж бодов. Гэтэл эхнэрийнхээ царайг хараад тэрээр дахин юу ч хэлж чадалгүй өөрийгөө буруутгасаар өнгөрөв. Үүний дараа өдөр нь нөхөр нь ядарч бие нь сульдсан байсан учир ажлаасаа чөлөө авч гэртээ өнжихөөр болов. Тэгээд тэр ус уухаар галын өрөөндөө ороод шилэн аяганд ус аваад ууж зогстол гэрийнх нь утсанд дуут шуудан ирэв. Нөхөр нь утсаа аваад шууданг сонстол нэгэн эр "Хонгор минь, би танайд очиж явна. Би аз жаргалыг мэдрүүлнэ" гэж хэлжээ. Үүнийг нөхөр нь сонсоод тэсэлгүй аягатай усаа газар унагаав, эхнэр нь ирж "Юу болсон бэ?" гэтэл нөхөр нь ихэд уурлаж эхнэрээ түлхэв харамсалтай нь эхнэр нь унахдаа хагарсан аяган дээр унаж ухаангүй болов. Нөхөр нь маш их айж эхнэрээ сэргэхийг гуйж уйлав. Тэгээд түүний гарт нэгэн захиа байхыг олж харан уншив. "Хайрт минь би чамдаа маш их хайртай, чамдаа дуулгах маш сайхан мэдээ байна, шууд хэлье гэсэн боловч нэг л зүрхлэхгүй байна, чи минь дуртай буйдан дээрээ сууж байгаад энэ захиаг уншаасай гэж хүсээд энэ захиаг буйдан дээр үлдээлээ. Хайрт минь бид хоёрын тухай миний өөр айлд үрчлүүлсэн ах маань найзаасаа сонсож над дээр ирсэн бид хоёр нэг нэгнээ хараад ихэд баярлаж бүхнийг ярилцсан тэр хамгийн сайхан нь маш сайн эмч , тэгээд би түүнд бид хоёрын тухай зовлонг хэлсэн. Тэр маш үнэтэй эмчилгээг өөрөөсөө мөнгө гарган шаардлагатай зүйлсийг нь худалдан авч хийсэн. Одоо миний хэвлийд чи бид хоёрын хүүхэд бий болсон хайраа, хоёр сартай гээд боддоо. Өнөөдөр ах маань ирж ямар "хүүхдүүд" болохыг бид хоёрт хэлнэ, бид хоёрт тэр аз жаргалыг мэдрүүлэхээр ирнэ" гэж бичсэн байв, нөхөр нь захиаг уншаад ухаанаа алдаж юу болоод байгааг ч ухаарсангүй. Гэтэл гэрийн хаалга дуугарав. Ах нь орж ирээд дүү нь газар хэвтэж байгаад шууд олж үзэв. Тэгээд

түүнийг яаралтай эмнэлэг үрүү хүргэн. Сэргээн амьдруулах тасгийнхнаас амийг нь гуйв. Ах нь сэргээн амьдруулах тасгаас гарч ирээд нөхөр лүү нь хараад "Тэд чадахаараа зүтгэж байна, түүний амийг аврах болно гэж бодож байна. Уул нь та хоёрт хэлэх гайхалтай мэдээ байлаа. Түүний хэвлийд хоёр ихэр хүү бойжиж байгаа" гэв. Нөхөр нь үүнийг сонсоод итгэж ядан, эхнэрээ, мөн хоёр хүүхдээ амь гарахыг бурхнаас гуйж өөрийгөө аймшигтайгаар зүхэв. 2 цагийн дараа их эмч гарч ирээд нөхөр лүү нь ихэд зэмлэнгүй харцаар харж байв нөхөр нь түүнийгээ алдлаа гэж бодож өөрийнхөө амийг хороохоор хүртэл бодож эхлэв, гэтэл эмч удалгүй толгой дохив.

Эмч нар эхнэрийг нь хоёр хүүхэдтэй нь аварч чаджээ. "Юу ч болсон бай аливаа зүйлийг хүчээр биш ухаанаар зохицуул, биеэ хянаж сур, амьдралд юу тохиолдож мэднэ. Үргэлж аз дайрдаггүйг сана. "

## ГЭР БҮЛИЙН ҮНЭ ЦЭНЭ

Хоёр залуу зэргэлдээ амьдардаг байжээ. Тэдний амьдрал тэмээ ямаа шиг ялгаатай юмсанжээ. Нэг залуу нь эд хөрөнгө, мөнгө төгрөг, эрх мэдэл, албан тушаал гээд цөм байхад нөгөөх залууд нь ядуу тарчигдуу амьдралтай, хоёр идэхгүй хоосон хонохгүй амьдардаг байж. Баян залуу дутагдах гачигдах зүйлгүй хангалуун амьдардаг хэдий ч түүнд гэр бүл үр хүүхэд гэх зүйлгүй, харин ядуу залууд хайрлах хань, асрах үр хүүхэд байдаг байжээ.



Ядуу залуугийн гэрээс үргэлж хөөрөн баясах хүүхдийн дуу хоолой, жаргалтай гэгч нь инээмсэглэх бүсгүйн инээд хангиндаг байв. Харин баян эрийн гэрт түнэр харанхуй л ноёлдог байжээ. Тэрээр хэчнээн найз нөхөд хань ижилтэй болж болох ч түүнийг хүрээлэн байгаа хүн бүр эрх мэдэл, албан тушаалд нь дуралсан бялдууч хүмүүс байдгийг мэдэх учраас одоо хэр ганцаар амьдарсан хэвээр байгаа ажээ. Баян эр үргэлж нэг зүйлийг боддог байсан нь ядуу залууг яагаад үргэлж инээмсэглэн жаргалтай гэгч нь алхалдаг байсныг огтоос ойлгодоггүй байжээ. Нэгэн удаа баян эр ядуу залуутай харц мөргөлдөхдөө тэсгэлгүй асууж орхив.

- Чамд юу ч байхгүй хоосон ядуу өлмөн зэлмэн амьдардаг хэрнээ яагаад ийм

жаргалтай гэгч нь алхалдаг юм, гэхэд ядуу эр өөдөөс нь инээмсэглэнгүй харснаа - Би биш чи л жинхэнэ ядуу хүн гэжээ.

## ҮНЭ ЦЭНЭ

Нэгэн багш олон мянган хүн цугласан семинар дээр халааснаасаа 100 долларын дэвсгэрт гаргаад ийнхүү хэлсэн байна. "Энэ мөнгийг авахыг хүсэж байгаа хүн байна уу?" тэнд байсан ихэнх хүн гараа өргөв.

"Та нарын дундаас нэг л хүнд энэ мөнгийг өгье гэж бодож байна. Гэвч эхлээд миний гар руу анхаарлаа хандуулна уу?" гэснээ нөгөө 100 долларын дэвсгэрийг базаж орхив.

"Одоо ч гэсэн энэ мөнгийг авахыг хүсэж байна уу?" гэхэд багшийн үйл хөдлөлд гайхсан мөртлөө хүмүүс дахиад л гараа өргөв. Багш энэ удаад нөгөө 100 доллараа шалан дээр хаяж, улан дороо дэвслэн, муухай болгожээ. Үрчийсэн 100 долларын дэвсгэртийг бариад "Одоо хүртэл энэ мөнгийг авахыг хүсэж байна уу?" гэж асуухад ахиад дийлэнх нь гараа өргөсөн байна. Энэ үед багш чангаар ингэж хэлжээ. "Би энэ 100 долларыг хичнээн улан доороо дэвсэлж, базаж, муухай болгосон ч мөнгөний үнэ цэнэ нь яг хэвээрээ гэсэн үг юм. Та нар ч гэсэн амьдрал гэсэн тайзан дээр олон удаа доош унаж, гишгүүлж, муухай болж байсан байх. Бүтэлгүйтэж цөхрөхөөрөө ихэнх хүн эхлээд өөрийгөө дүгнэх гэдэг. Гэвч үүнийг санаж яваарай. Миний гутлын уланд гишгүүлж муухай болсон ч өөрийнхөө үнэ цэнийг хэвээр хадгалж байгаа энэ дэсгэрттэй адил та бүтэлгүйсэн ч үнэ цэнэтэй хэвээрээ байх болно."

## ХАЙР АЗ ЖАРГАЛЫН ТҮЛХҮҮР

Ах, дүү хоёр зэргэлдээ байшинд амьдардаг байжээ. Дүүгийн дээр нь баяр хөөр дүүрэн байхад харин ахынхаас нь хэрүүл маргаан салдаггүй байлаа. Нэгэн өдөр ах



нь дүүгийн дээр ортол, дүү нь өөрт нь богинодчихсон өмд өмчихсөн байв. Ах нь ихэд гайхаж "Яагаад богинодчихсон өмд өмсөө вэ?" гэж асуухад дүү нь "Зах гараад өөртөө өмд авсан чинь уртдуулчихжээ. Надад уртадсаныг мэдээд эхнэр маань доороос нь хассан юм. Гэтэл том охин ээжийгээ завгүй, амжаагүй байх гэж бодоод мөн доороос нь хасчихжээ. Дунд охин бас санаачлагаараа хассан чинь ийм богино гэж яриу. Үүнийг сонсоод атаархсан ах нь шууд зах гарч өөртөө арай уртдуулж өмд аваад

гэр

бүлийнхнээсээ хасч өгөхийг гуйв. Маргааш нь авсан өмдөө үзэхэд хасаагүй, хэвээрээ л байв. Би чамд хэлээ биздээ гэж эхнэртээ уурлахад эхнэр нь “аавынхаа өмдийг хас гэж хэлсэн биз дээ” хэмээн том охиноо зэмлэв. Харин том охин нь “чи яагаад хасаагүй юм бэ?” гэж дүүрүүгээ уурлав. Бие биенийхээ төлөө гэсэн сэтгэл, хайргүйгээр яаж ч аз жаргалтай амьдрах билээ дээ! Хүүхдүүдээ та нар аав, ээж, ах, эгч, дүү нараа жинхэнэ халуун сэтгэлээр хайрлаж, халамж анхаарал тавьж сураарай. Тэгж чадвал чи аз жаргалын түлхүүрийг атгалаа л гэсэн үг.

## ЭЭЖИЙН ЗӨВЛӨГӨӨ

Хадамд гарсан охин нь төрсөн гэрээ үүрд орхин гарахын өмнө ээж нь өмнөө суулгаад духан дээр нь удаан гэгчийн үнсэв. “За, үр минь чамдаа ганцхан зүйлийг захия. Хувь заяагаа холбон буй эр нөхөр чинь чамайг голгүй гомдоохын цагт хэзээ ч битгий муу үг хэлж, муугаа үзүүлээрэй. Харин шүд зуун тэвчиж байгаад, тэр тоолон хоёр хөөрхөн хүүхэлдэй нэхээд байгаарай” гэж эх хэлжээ. Бүсгүй эм хүн болж, эхнэр болж, эх хүн болж, эмээ болов. Өвчний дүрээр ирсэн үхэл орны толгойд зогсохын үед эмгэн өвгөнөө дуудаад, нандигнан нуусан нэгэн хайрцагны байгаа газрыг зааж өгчээ. Өвгөн хайрцгийг нээвэл эр эм хос хүүхэлдэй, бас маш их мөнгө байв. “Чи намайг гомдоох үед үүнийг нэхсэн юмаа” гэж эмгэн хэлэв. Өвгөний нүдэнд нулимс дүүрч “Уучлаарай, миний амьдралын хамгийн үнэт хүн минь” гэж хэлэв. Санаатай санаагүй үй олон нүглүүд нүдний өмнүүр хөврөхөд цорын ганц удаа ч гомдоллон уйлж байгаагүй эхнэр нь нэгхэн хос хүүхэлдэй нэхсэнд баярласан нь тэр байж. “Харин наад мөнгийг чинь нэхсэн хүүхэлдэйнүүдээ зарж олсон юмаа” гэж эмгэн хэлжээ.

